



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Төрийн захиргааны албан тушаалыг дипломат
албан тушаалд дүйцүүлэн шинэчлэн батлах тухай

Дипломат албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дэх хэсэг, “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлтэй зөвшилцсөн /ГАЗ-ийн 2015 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн 1313 тоот/ -ий үндсэн дээр ТУШААХ НЬ:

1. Төрийн захиргааны албан тушаалыг төрийн тусгай албаны дипломат албан тушаалд дүйцүүлэн хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Гадаад хэргийн яамны төв аппаратад болон Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа дипломат ажилтнуудын цалин, адилтгах цалинг төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээний дагуу шинэчлэн тогтоож, 2015 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Тэгшжаргал, ТЗУГ-ын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Б.Барбаатар нарт даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гадаад хэргийн сайдын “Дипломат албан тушаалыг сэргээн хэрэглэх тухай” 2000 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 50 дугаар тушаал, “Төрийн захиргааны албан тушаалыг төрийн тусгай албаны албан тушаалд дүйцүүлэн батлах тухай” 2001 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 23 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ПҮРЭВСҮРЭН

Гадаад Хэргийн сайдын 2015 оны
 178 тоот тушаалын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫГ ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАНЫ
 ДИПЛОМАТ АЛБАН ТУШААЛД ДҮЙЦҮҮЛСЭН БАЙДАЛ

Төрийн захиргааны албан тушаал		Төрийн тусгай албан тушаал	
Зэрэглэл	Албан тушаал	Зэрэглэл	Дипломат албан тушаал
T3-14	Төрийн нарийн бичгийн дарга	ТТ-18	Төрийн нарийн бичгийн дарга
T3-12	Яамны газрын дарга	ТТ-17	Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд Газрын захирал
T3-11	Газрын орлогч дарга	ТТ-16	Газрын дэд захирал
T3-10	Хэлтсийн дарга		Хэлтсийн дарга
T3-9	Тасгийн дарга	ТТ-15	Тасгийн дарга
T3-8	Ахлах мэргэжилтэн	ТТ-14	Зөвлөх
		ТТ-13	Нэгдүгээр нарийн бичгийн дарга
T3-7	Мэргэжилтэн	ТТ-12	Хоёрдугаар нарийн бичгийн дарга
		ТТ-11	Гуравдугаар нарийн бичгийн дарга
T3-6	Туслах мэргэжилтэн	ТТ-10	Атташе